



МОНГОЛ УЛСЫН
ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1998 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Гадаадад магистрантурт
суралцуулах тухай

ТУШААХ НЬ:

1. Дашдоржийн Жамьяанааг АНУ-ын Колорадогийн Их сургуульд Экологийн менежментийн, Ганболдын Энхтунгалагийг АНУ-ын Деневерийн Их Сургуульд Эрх зүйн, Сономын Олонбаярыг Английн Манчестерийн Их Сургуульд холбооны инженерийн, Авирмэдийн Даваасүрэнг ОХУ-ын Эрхүүгийн Эдийн засгийн Академид эдийн засгийн, Аюурзанын Бурмааг АНУ-ын Зүүн Дакотын Их Сургуульд Программ хангамжийн, Чимэдрэгзэнгийн Болортуяаг АНУ-ын Бриджпортын Их Сургуульд философийн, Батсуурийн Золтуяаг Женевийн Их Сургуульд эрх зүйн мэргэжлээр 1998\1999 оны хичээлийн жилээс эхлэн Магистрантурт тус тус суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67\131 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй орны магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сангийн захирал \Б.Ганбат\ -д, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга \С.Алтангэрэл\ -д тус тус даалгасугай.

САЙД

Ч.САЙХАНБИЛЭГ